

Маргааны товч:

О.Батмөнхөөс Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан “ ... 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 251 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах, урьд эрхэлж байсан ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх” нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Нэхэмжлэгчээс “ ... Миний бие 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Засгийн газрын тохируулагч агентлаг-Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон тооны гишүүнээр томилогдон ажилласан. Тус байгууллага нь Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Монополын эсрэг газар болж өөрчлөн байгуулагдсан боловч бүтцийн ямар нэг өөрчлөлт хийгдээгүй, орон тоо байхгүй болоогүй, мөн цөөрөөгүй, зөвхөн нэр нь өөрчлөгдсөн. Гэтэл намайг байгууллага өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан орон тооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсөн нь хууль зөрчсөн. Өрсөлдөөний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу миний бүрэн эрхийн хугацаа 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр дуусах ёстой байсан ...” гэх зэрэг үндэслэлээр,

хариуцагчаас “... Орон тооны гишүүний ажлын байр нь Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөгдсөн албан тушаалын тодорхойлолт байдаггүй, Өрсөлдөөний тухай хууль болон Монополын эсрэг газрын дүрэмд зааснаар агентлагийн даргын хуваарилсан ажил, үүргийг хэрэгжүүлэн ажилладаг, хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Монополын эсрэг газрын хуралдаанд оролцож шийдвэр гаргах эрхтэй этгээд юм. Монгол Улсын Ерөнхий сайд нь Монополын эсрэг газрын орон тооны гишүүнийг томилж, чөлөөлөх хуулиар олгогдсон эрхийг хэтрүүлсэн гэх үндэслэлгүй. Маргаан бүхий Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 251 дүгээр тогтоол нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлд заасан илт хууль бус захиргааны акт биш. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэх агуулгаар тус тус маргажээ.